



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БЭРХ ХОТЫН ЗАХИРАГЧИЙН
ЗАХИРАМЖ**

2026 оны 01 сарын 26 өдөр

Дугаар А/07

Бэрх хот

Ахмад настанд хүндэтгэл үзүүлж,
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын “Хот тосгоны эрх зүйн байдлын тухай” хуулийн 25 дугаар зүйлийн 25.1, “Төсвийн тухай” хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, “Ахмад настны тухай” хуулийн 12 дугаар зүйлийн 12.4 дэх заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралт “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.6 дугаар заалт, Захирагчийн зөвлөлийн 2026 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн №01 дүгээр хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сар шинийн баяр болохтой холбогдуулан Бэрх хотын ахмад настнуудад гарын бэлэг гардуулан хүндэтгэл үзүүлсүгэй.

2. Хүндэтгэл үзүүлэхэд шаардагдах 2.000.000 (Хоёр сая) төгрөгийг Захирагчийн нөөц сангаас хууль, дүрэм журмын дагуу гаргаж зарцуулахыг нягтлан бодогч (Г.Осгонжаргал)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүүгийн албаны дарга (П.Янжмаа)-д даалгасугай.

ЗАХИРАГЧИЙН ЗӨВЛӨЛ
Ч.ЭНХЖАВХЛАН



232601014